

## **Түүх, иргэншил**

### **Монгол-Америкийн харилцааны түүхээс**

*А.Дамдинсүрэн*

АНУ нь XIX зууны сүүл үеэс Монголтой аль болохоор ойртож харилцаагаа өргөжүүлэх бодлого баримталж ирсэн юм. Гэтэл Хаант Орос нь Монголыг Америктай ойртуулахгүй, түүний эдийн засаг, соёлын өндөр хөгжлийн сайн нөлөөг Монголд нэвтрүүлэхгүй хаалттай орон байлгаж дангаар эзэмшихийн тулд ил далд олон арга хэрэглэж байв.

1896 онд Америкийн төмөр зам, хөлөг онгоц болон банкны фирмүүдийн нэгдсэн синдикатын нэрийн өмнөөс ноён Баш Монголд “газар, ой мод, уурхай нээж ашиглах эрх олох тухай саналыг Манжийн засгийн газарт тавьжээ. Манжийн засгийн газар Хаант Оросын шахалтаар ноён Баш-д концесс” олгохоос татгалзжээ.

Монголд 1900 онд байгуулсан Америкийн “Монголор” гэдэг алтны уурхайд АНУ-аас үлэмж бага хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ирүүлж байсны дээр 40 гаруй америк инженер, техникийн ажилчдыг урин ажилуулж байжээ. Эдгээр мэргэжлийн ихэнхи нь Ерөөгийн алтны уурхайд ажиллаж “Монголоор” уурхайг америк маягийн боловсронгуй болгохыг зорьж байжээ. Тэр үед Их Хүрээнд америк хүмүүс нэлээд олон байсны дээр америкийн пүүс-дэлгүүр ажиллаж байсан. Стукензергагений пүүс жилдээ 100.000 пүү ноос худалдан авч Америк, Англи руу явуулж байлаа. Америкийн Рихардын пүүс ноос худалдан авдаг байжээ.

1900 онд америк хүн Линдон Бэйтс Монголд ирж монголын улс төр, эдийн засгийн байдалтай танилцаад нутагтаа очоод “Хятадад очих Оросын зам” гэдэг зохиолдоо: Монголоор туушид нь төмөр зам байгуулбал Америкаас Азийн гүн рүү худалдаа хийх боломж нээгдэх юм гэж тэмдэглэсэн нь Монголд нөлөөгөө тогтоохыг өгүүлжээ.

Хаант Орос болон Хятадад элчин сайдаар сууж байсан америкийн нэртэй дипломат В.Рокхиль Монголын байдалтай танилцахаар 1912 оны 12 дугаар сард Хүрээнд иржээ. Тэр үед албан хэргээр Петербургт байсан Ерөнхий сайд Сайн ноён хан Намнансүрэн ирүүлсэн цахилгаандаа: Рокхиль бол Далай ламтай сайн харьцаатай хүн тул хэрэв тэр хүн хүсвэл Богд хаантай уулзуулах хэрэгтэй” гэж захиж байжээ.

Богд хаант Монгол улсын үед Америкаас Хүрээнд худалдааны ажил эрхэлж байсан Ф.Ларсон Монгол-Америкийн харилцааг ойртуулахад зохих хувь нэмэр оруулах гэж чармайж байсан учир Богд хааны засгийн назар Ф.Ларсонд гүнгийн зэрэг хэргэмээр шагнаж байсан юм. Богд хаан нь Америк улсыг ихэд талархаж дэмжлэг тусалцаа авахыг эрмэлздэг хүн байлаа. Богд хааны Засгийн газар америкийн капитал Монголд нэвтрэхийг идэвхитэй дэмжиж байлаа.

1916 онд Америк: Чуулалт хаалганд өөрийн хөрөнгөөр “Монголын худалдааны компани” гэдэг тээврийн пүүс байгуулж, Хүрээ, Хаалганы хооронд авто тээвэр хийх болжээ. Үүний дараахан “Андерсон Мейер ба К” хэмээх америк пүүс өөрийн салбарыг Хүрээнд нээн ажилуулав.

Америкийн “Миллиард ревью” сэтгүүлд (1918) “Олон улсын худалдааны тусын тулд Хаант Монгол улсыг нээсэн нь” гэсэн өгүүлэлд “түүхий эдээр бусдыг хангах ба Америк, Европын үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулах өргөн боломжтой зах зээл болох тавилантай гадаад Монголыг одооноос олон хүн шинэ ертөнц мэт үзэх боллоо” гэж бичиж байжээ.

АНУ-ын Төв Азийг судлах шинжилгээний анги удирдагч профессор Р.Ч.Эндрюс 1916 онд монголын нийслэл Хүрээнд автомашинаар ирж, америкийн “Андерсон-Мейер” пүүсийн төлөөлөгч Ф.Ларсоноор дамжуулан Богд хаан хүлээн авч уулзжээ. Богд хаан тэдний шинжилгээний ангийн ажилд анхаарал тавин газарч, хэлмэрч, уналга хөсөг зэрэг бүхий л талаар тусалцаа үзүүлжээ. Тэр үед Богд хаан анх удаа автомашинтай танилцаад их сонирхон, ийм машин худалдан

авахыг хүсэхэд Ч. Эндрюс Чуулалт хаалганаас шинэ машин авчруулан Богд хаанд өгчээ. Үүнд: Богд хаан Баярлан талархаж байгаагаа ноён Ч. Эндрюс монголд ирсэнтэй холбогдуулан R.C. Andrews" Across Mongolian plains" New York-London, 1921. гэдэг том бүтээлдээ Монгол орны 1916 оны үеийн байдлыг бодитой үнэлэхийн хамт Богд хааны засгийн газрыг хүндэтгэсэн үзэл санаагаар туурвижээ.

Р.Ч.Эндрюс "Монгол нь өнөөдөр Аляскийг оролцуулахгүйгээр АНУ-ын нутгийн талаас их нутаг дээр энэ хэдхэн сая монголчууд амьдарч байна. Тэдний эрэгтэйчүүдийн ихэнхи нь лам нар, шашны номоос өөр иргэний ямар ч боловсролгүй, тэдний удирдлага нь ажил хийхгүй, залхуу, иймд тэдний хүүхдүүдийг шашнаас холдуулахын тулд гагцхүү хар хүмүүс, малчдад нь мөнгөөр тусалж өөд татах хэрэгтэй юм" гэж тэр үеийн монголын байдлыг нүдээр үзээд тун их харамсан бичиж байжээ.

Богд хааны Засгийн газар АНУ-аас дэмжлэг авах гэж чармайж байсны бас нэг гол шалтгаан нь АНУ-ын Ерөнхийлөгч Вудро Вильсон 1918 онд тунхаглахдаа: "Бага буурай орны төрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилт" дэвшүүлсэн нь монголчуудын тусгаар тогтнолын төлөө тэмцэлд АНУ дэмжлэг үзүүлнэ гэсэн найдлага төрүүлсэн юм.

Монголын Нийслэл Хүрээнд 1916 онд анхны цахилгаан станц байгуулахад түүний зарим тоног төхөөрөмжийг АНУ-аас авч байжээ. Нэг үгээр хэлбэл монголчууд америкийн дэмжлэгтэйгээр гэртээ гэрэлтэй болсон түүх ингэж эхэлдэг.

ХИХ зууны сүүлч, ХХ зууны эхээр Монголд АНУ-аас элч, төлөөлөгч, жуулчид, шинжээчид, эрдэмтэд, худалдаачид зэрэг янз бүрийн ажил мэргэжлийн хүмүүс олон ирж тэр үеийн Монгол орны нийгэм-эдийн засгийн байдал, Чингис хааны гүрэн байгуулж байсан төрийн уламжлалын талаар АНУ-ын хэвлэлд янз бүрийн хэлбэрээр олонтаа нийтлэхдээ Төв Азид ийм нэг түгжигдмэл мөртлөө дэлхий дахины эрдэмтэд, судлаачид, худалдаачдын анхаарал татсан өвөрмөц сонин орон байдаг гэдгийг сурталчилж байлаа.

Харин энэ үед Хаант Орос, Хятад хоёр нь Монгол орныг хуваан эзэмшиж байсан учир Монгол орны тухай хэвлэлд огтхон ч бичихгүй, аль болохоор түгжигдмэл орон хэвээр байлгахыг зорьж байлаа.